**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 08 өдөр                Дугаар А/278                Арвайхээр сум

Үнэлгээний хорооны нарийн бичиг,
гишүүн нөхөн томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сургуулийн барилга, 320 суудал (Өвөрхангай, Арвайхээр сум, 2 дугаар сургууль) ажлын тендерийн үнэлгээний хорооны гишүүн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын хэлтсийн дарга А.Энхцэцэгийн мэргэшсэн ажилтны гэрчилгээний хугацаа уг төсөл арга хэмжээг зарлагдах явцад дуусгавар болсон тул үнэлгээний хорооноос чөлөөлж, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн Ц.Нямдалайг нөхөн томилсугай.

2.ЭМГ/20240102068 урилгын дугаартай Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж (Өвөрхангай) ажлын тендерийн үнэлгээний хорооны нарийн бичиг Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн Б.Пүрэвсүрэнг уг төсөл арга хэмжээний үнэлгээний хорооноос чөлөөлж, тус газрын ахлах мэргэжилтэн Т.Эрдэнэсүрэнг нөхөн томилсугай.

ЗАСАГ ДАРГА                                        И.ДОРЖСҮРЭН

0224 11 0570

D:My Doc. Zahiramj. Zasag darga